



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/660

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Батдайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу дараах иргэдэд шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

а.90 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Дагвын Пүрэвсүрэн /ПЖ91070811/-д хаягийг Батмонгол 2 дугаар гудамжны 205 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

б.90 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Бямбадоржийн Даваасүрэн /ПН95052211/-д хаягийг Батмонгол 2 дугаар гудамжны 202 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

в.74 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Зоригтбаатарын Бат-Ерөөл /ПЮ97101651/-д хаягийг Батмонгол 1 дүгээр гудамжны 106 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

г.74 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Дагдмаагийн Даваахүү /ПН92042104/-д хаягийг Батмонгол 1 дүгээр гудамжны 107 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

д.74 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Батбуянгийн Дарьчулуун /ПЗ91111016/-д хаягийг Батмонгол 1 дүгээр гудамжны 105 тоот болгон 15 жилийн хугацаагаар,


е. 90 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Тулгаагийн Анхбаяр /ПЭ89032426 /-д хаягийг Батмонгол 2 дугаар гудамжны 200 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

ё. 73 метр квадрат газрыг амины орон сууцны зориулалтаар Хойчбайгийн Эсенкельд /ПЛ95040113/-д хаягийг Батмонгол 1 дүгээр гудамжны 108 тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ